



**БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ**

**2025 ОНЫ 01 ДҮГЭЭР  
САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

**СӨҮЛ ХОТ**

**2024 оны 02 дугаар сарын 07-ны өдөр**

Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 55 дугаар “Төсвийн зарим байгууллагыг өөрчлөн зохион байгуулах, татан буулгах” тогтоолын 1.7-д заасны дагуу Хөдөлмөрийн яамны (хуучин нэрээр) харьяа “БНСУ дахь Нэг цэгийн үйлчилгээний төв” болон Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны (хуучин нэрээр) харьяа “БНСУ дахь Нийгмийн хамгааллын үйлчилгээний төв”-ийг нэгтгэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа “БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” болж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг, Нийгмийн даатгалын тасагтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус төв нь Монгол Улсын болон БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам хоорондын “Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцооны дагуу БНСУ-д ажиллах хүч илгээх тухай” харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд ажил олгогч, ажилтан хоёрын хооронд байгуулсан хөдөлмөрийн гэрээний биелэлтийг хангуулах, хяналт тавих, иргэдийн эрх ашгийг хамгаалах, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх, тус улсад амьдарч буй Монгол Улсын иргэдийг хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг хангуулдаг.

Тайлант хугацаанд чиг үүргийн хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн.

- I. АЖИЛЛАХ ХҮЧ ИЛГЭЭХ САНАМЖ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ
- II. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТ
- III. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ

## **ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТАСАГ**

### **I. АЖИЛЛАХ ХҮЧ ИЛГЭЭХ САНАМЖ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ**

#### ***1. БНСУ-д Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдэд дэмжлэг үзүүлэх, мэдээллийн санд баяжилт хийх арга хэмжээ***

1.1.1 Е-7-4 визний асуудлаар нийт 27 иргэнтэй утсаар болон цахимаар холбогдож оноо цуглуулах, гэр бүлээ урих, ТОПИК шалгалт болон нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн сургалтад бүртгүүлэх, визний ангиллаа дараагийн ангилал руу өөрчлөх талаар мэдээлэл, зөвлөгөө өгөн бүртгэлийн санд бүртгэсэн.

1.1.2 БНСУ-д шинээр хөдөлмөрийн гэрээгээр ирсэн ажилтнуудын мэдээллийг нэгтгэн, мэдээллийн сан үүсгэж мөн тус улсад ажиллаж амьдарч буй монгол иргэдийн судалгааг шинэчлэн ажиллаж байна.

#### ***2. БНСУ-д оршин сууж байгаа монгол иргэдэд сэтгэл зүйн тулгамдсан асуудлаар үйлчилгээ үзүүлэх арга хэмжээ***

1.2.1 Сэтгэл зүйн зөвлөгөө, ганцаарчилсан сэтгэл засал нийт 14 хүнд, нойргүйдэл, сэтгэл гутрал болон сэтгэл түгшилт илрүүлэх сорилыг 31 хүнд хийж, сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн.

## **НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТАСАГ**

### **II. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТ**

#### ***1. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа болон бусад хэлбэрээр ажиллаж, амьдарч байгаа иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалд албан журмаар болон сайн дураар хамруулах нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх арга хэмжээ***

2.1.1 БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд албан журмаар 15 иргэнийг хамруулж, холбогдох программд мэдээллийг бүртгэн гэрээ байгуулсан. Мөн Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээний хугацааг сунгаж 39 иргэнд, гэж үрэгдүүлэн дахин авах хүсэлт гаргасан 1 иргэнд тус тус олгосон.

2.1.2 БНСУ-д хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн визний ангиллаар оршин сууж буй Монгол Улсын 60 иргэнийг нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулан, холбогдох программд мэдээллийг бүртгэж гэрээ байгуулсан. Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх хүсэлт ирүүлсэн 42 иргэнд гэрчилгээ олгосон.

## 2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, тайлагнах арга хэмжээ

2.2.1 Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны А/01 дугаар тушаалаар тус тасгийн 2025 оны орлогын батлагдсан төлөвлөгөө 5,031,634,000.00 төгрөг, сар бүрийн орлогын төлөвлөгөө 419,302,833.33 төгрөг болно. Тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 64 хувиар биелүүлсэн.

Хүснэгт 1: Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төвлөрүүлэлт

Сар	Сарын орлогын төлөвлөгөө /төгрөгөөр/	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого		Сайн дурын даатгалын шимтгэлийн орлого	Нийт төвлөрүүлсэн шимтгэлийн орлого		Биелэлтийн хувь	Тухайн сарын МБ-ны эхний өдрийн хаалтын ханш
		Вон	Төгрөг	Төгрөг	Вон	Төгрөг		
1	419,302,833.33	47,490,000.00	110,176,800.00	157,429,518.00	47,490,000.00	267,606,318.00	64	2.32

2.2.2 Нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн 01 дүгээр сарын шимтгэлийн орлогыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Төрийн сангийн дансанд шилжүүлэх, сарын мэдээг заасан хугацаанд гаргаж, шилэн дансанд байршуулсан.

Сангийн тайланг шинэчилсэн “Sicos” программаар гаргах болсон тул давхардсан тоогоор 2024 оны албан журмын даатгуулагчдын шимтгэл төлсөн 10,000 орчим банкны гүйлгээний мэдээллийг нэг бүрчлэн тус программд таниулах ажлыг хийж байна.

## III. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ

### 1. БНСУ-д амьдарч буй иргэд болон хөдөлмөрийн гэрээт иргэдэд сургалт, сурталчилгаа зохион байгуулах, гадаад хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1.1 БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирэх 55 иргэнд ирэхийн өмнөх сургалтыг 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр, 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрүүдэд цахимаар, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлтийн хөгжлийн сангийн Ёжү хот дахь Олон улсын сургалтын төвд 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр мөн 49 гэрээт иргэнийг хамруулан ирсний дараах сургалтыг танхимаар зохион байгуулж дараах агуулгын хүрээнд мэдээлэл өгөв. Үүнд:

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн үйл ажиллагааны танилцуулга
- Цалин хөлс тооцох, ажлын байр солих талаар
- Үйлдвэрлэлийн ослын даатгал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ослоос урьдчилан сэргийлэх тухай
- Солонгос улсын хууль, журам, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар
- Суугаа орондоо дасан зохицоход анхаарах зүйл
- Ур чадвартай ажиллах хүч E-7-4 визний талаар
- Солонгос хэлний сургалт, урьдчилсан үнэлгээ хийх шалгалтуудын хуваарь
- Хууль бусаар оршин суухын сөрөг тал, хуулийн дагуу оршин суухын давуу тал гэх мэт.

Мөн ирэхийн өмнөх болон ирсний дараах сургалтын агуулгыг шинэчилсэн.

3.1.2 Тайлант хугацаанд **Нийгмийн даатгалын тасаг нь** нийт давхардсан тоогоор 788, үүнээс 765 иргэн, даатгуулагч, ажил олгогчид утсаар, 23 иргэн, даатгуулагчид биечлэн Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах талаар болон бусад төрлийн мэдээлэл, заавар, зөвлөгөө өгч, сурталчилгааны материал тараан ажилласан.

**Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг нь** 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрөөс 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр хүртэл хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлаа шийдвэрлүүлэхээр танхим, цахим, утсаар хандсан нийт 372 иргэнд БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, ажил олгогч эзэд болон холбогдох бусад байгууллагуудтай харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, гомдол барагдуулах, орчуулга хийх, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх зэрэг үйлчилгээ үзүүлсэн.

Хүснэгт 2: Үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо

Үйлчилгээ үзүүлсэн тоо	Утсаар	267
	Цахимаар	52
	Танхимаар	53
	Нийт	372

3.1.3 Төвийн БНСУ дахь “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” сошиал хуудсанд 17 удаа, байгууллагын <https://seoulcenter.mlsp.gov.mn> цахим хуудсанд 13 удаагийн мэдээлэл, зөвлөгөө нийтэлж сурталчилснаар 89,155 хандалт авсан. Төвийн веб сайтыг шинэчилж, дата төвд хүсэлт гарган IP тохируулга хийлгэсэн. Монголчууд хамгийн олноор ажиллаж, амьдардаг Солонгос, Америк, Япон, Казакстан, Чех улсуудад оршин сууж буй Монгол иргэд, өрх, гэр бүлийн аж байдал, гэр бүлийн харилцааны нөхцөл байдлыг тодруулах зорилгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиалгаар “Хилийн чанад дахь Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, өөрчлөлт” судалгааг төвийн цахим хуудас болон бусад олон нийтийн сүлжээгээр сурталчилж иргэдийг хамрагдахыг уриалан, төвийн албан хаагчдыг хамруулсан.

3.1.4 БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яамны харьяа Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэрэг эрхлэх газартай 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдөр албан уулзалт зохион байгуулж 2024 онд хийж хэрэгжүүлсэн ажлыг дүгнэн, 2025 оны хамтын ажиллагааны чиглэлийг ярилцсан. Гёнгү аймгийн хойд бүсийн өргөмжит Консул Ань Гён Му болон бусад холбогдох албаны хүмүүстэй 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр албан уулзалт зохион байгуулсан. Уулзалтаар БНСУ-д ажиллаж амьдарч буй монгол иргэдийн ажиллаж, хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулахын тулд идэвхтэй хамтрах, хэд хэдэн төрлийн төсөл хэрэгжүүлэхээр ярилцсан. БНСУ-д хууль бусаар ажиллаж амьдарч буй иргэдийг эмнэлгийн үзлэг болон эрүүл мэндийн даатгалд хамруулах асуудлаар “JUBILEE” эрүүл мэндийн сайн дурын сантай хамтран ажиллаж, 2025 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр эмэгтэйчүүдийн нарийн мэргэжлийн үзлэгт 7 иргэнийг хамруулсан.

## **2. Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хүний нөөцийг чадавхжуулах, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах арга хэмжээ**

3.2.1 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, саналыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлсэн.

3.2.2 Солонгос хэлний түргэвчилсэн сургалтад төвийн 14 албан хаагч хамрагдаж анхан болон ахисан түвшний мэдлэг эзэмшсэн үнэмлэх авсан. Мөн шинэ ажилтны дотоод сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулсан.

3.2.3 Төвийн албан хаагчдаас 2024 оны архивын баримт бичгийг хүлээн авч, архив албан хэрэг хөтлөлтийн журмыг мөрдөн ажиллаж байна.

3.2.4 **Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг нь** БНСУ-д оршин сууж буй иргэдэд хөдөлмөрийн харилцаатай холбоотой өргөдлийг хүлээн авч, Самсунг даатгалын оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал, үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү, нутаг буцах зардал, үйлдвэрлэлийн ослын даатгал, олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс зэрэг хэлбэрээр нийт **96,535,368.00** воныг Монгол Улсын **49** иргэнд олгуулсан.

Хүснэгт 3: Ажил үйлчилгээний төрлөөр иргэдэд олгуулсан нийт мөнгөн дүнгийн жагсаалт

Ажил үйлчилгээний төрөл		Мөнгөн дүн /вон/
Хөдөлмөрийн гэрээт ажилчид	Буцах замын зардал	6,037,000.00
	Цалин, илүү цагийн хөлс	
	Самсунг даатгал дахь 13 дахь сарын цалин	66,005,800.00
	Үйлдвэрээс авах 13 дахь сарын цалин	5,793,408.00
	Үйлдвэрлэлийн ослын даатгал	4,732,800.00
Бусад төрлийн виз	Олгогдоогүй, хойшлогдсон цалин хөлс	
	Үйлдвэрлэлийн ослын даатгал	
Хууль бусаар оршин суудаг иргэдэд	13 дахь сарын цалин	366,360.00
	Олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс	13,600,000.00
<b>НИЙТ ОЛГУУЛСАН ДҮН</b>		<b>96,535,368.00</b>

**Нийгмийн даатгалын тасаг нь** Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан болзол нөхцөлийг хангасан 3 даатгуулагчдад тэтгэмжийн тодорхойлолт олгох, мөн нийгмийн даатгалын аппликейшнд бүртгүүлэх хүсэлт гаргасан 3 иргэнийг бүртгэсэн.

Мөн тус төвд ирүүлсэн 1 иргэний өргөдлийг хүлээн авч, хуульд заасан хугацааны дагуу шийдвэрлэх шатанд явж байна.